



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/379

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, Монголын Улаан Загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.5, Донорын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цусны донорын ач тусыг сурталчилан таниулах, донорын эгнээг өргөтгөх үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байгаа хүндэт доноруудыг урамшуулах, алдагдсан эрч хүчийг нөхөн сэргээх үүднээс Эрдэнэт Улаан-Үд -Байгаль нуур-Эрдэнэт чиглэлд аялахад санхүүгийн дэмжлэг үзүүлж, шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 2500000/ Хоёр сая таван зуун мянган / төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Улаан загалмайн хороо /н.Тунгалаг/-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Авто тээврийн төв /н.Эрдэнэцогт/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017оны
06 дугаар сарын 29-ний өдрийн
А/379 дугаар захирамжийн хавсралт

**ЭРДЭНЭТ -УЛАН ҮДЭ-БАЙГАЛЬ НУУР-ЭРДЭНЭТ
ЧИГЛЭЛД АЯЛАХАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Үйл ажиллагаа	Нэг бүрийн үнэ	Хэмжих нэгж	Бүгд
1	Шатахууны зардал /3000 км/	1650	1000 литр	1650000
2	Жолоочийн урамшуулал / ажлын хөлс, хоол, байрны зардал/	425000	2 хүн	850000
	Нийт			2500000

00